

Манмин Мэдээ

№ 37 2013 оны 8-р сарын 4

“Еэшуа, Эзэний нэрийг өндөрт өргөө!”

Израиль улсын Кристал Форумын зохион байгуулсан 2013 оны Магтаал Дууны их наадам



Эзэн Есүсийн төрсөн газар Израиль, Эзэний дуу хоолой сонсдох мэт Галил нуурын эрэг дээр сэтгэл хөдлөм, баяр хөөрөөр дүүрэн цуурайтах магтаал дууны наадамд дэлхийн өнцөг булан бүрээс ирсэн 1700 орчим хүн оролцож, дэлхий даяар шууд цацагдаж байлаа. (Зүүн дээд талд Магтан Дууны удирдагч Хан Жү гёон номлогч; баруун талд нь Глори Вошип бүжгийн баг)

Өнгөрөгч 2013 оны 5 сарын 17нд Кристал Форум (Израйлийн пасторуудын холбоо) 2013 оны Магтаал дууны их наадамыг Эзэний оршихуйг санагдуулах Израиль Галил нуурын эрэг дээр гадаа талбайд зохион байгууллаа.

Энэхүү үйл ажиллагаа нь Оросын TBN-ээр дэлхий даяар шууд цацагдсан бөгөөд Израиль улсаас гадна ойролцоогоор 1700 орчим хүн Америк, Орос, Беларус, Герман, Шведээс хурэлцэн ирсэн билээ. Тэд гадаа задгай талбайд Эзэн Есүс Христийн нэр ямар агуу хүчтэй, үр нөлөөтэй, үнэн болохыг батлан харуулж эр зоригтойгоор магтан дуулж, бүхий л алдар магтаалыг Түүнд өргөж байлаа. Мөн Тэргүүн пасторын гурван жилийн турш хийсэн үйлчлэлийн дараа Израйльд бий болсон Кристал Форум хэрхэн хүчирхэг болсоныг ч батлан харуулж чадлаа.

Израйльд Христэд итгэгчид маш цөөхөн байдаг бөгөөд ард түмний ихэнхи нь Иудейн шашиныг шүтдэг. Хэдийгээр Израйлийн хуулинд шашин шүтлэг нь эрх чөлөөтэй гэж тусган заасан байдаг ч еврейчүүд христэд итгэхийг хүлээн зөвшөөрдөггүй байна. Тиймээс Эзэн Есүс Христэд итгэдэг еврейчүүд нийгмээс гадуурхагдаж, пастор, номлогч нар эдийн засаг, санхүүгийн тал дээр хүнд байдалтай, маш хэцүү дарамт шахалтанд амьдардаг байсан.

И Жей руг Тэргүүн пастор нь 2007-

2009 оны хооронд гурван жилийн турш арван хоёр удаа айлчлан Израйлийн бүх нутгаар ариун сайн мэдээг болон эрх мэдэлт хүчээр гайхамшигт үйлсийг үйлдэн, Бурханы агуу хүчийг батлан харуулсан юм. Бурханы агуу хүчийг гэрчлэгч И Жей руг Тэргүүн пасторын хүч чадлыг мөн Израйль руу хандсан Бурханы агуу хайр энэрлийг Израйлийн пасторууд ойлгон ухаарч, хүлээн зөвшөөрсөн учраас 2008 онд Кристал Форумыг үүсгэн байгуулсан билээ.

Тэд 2009 оны 9 сард И Жей руг Тэргүүн пасторыг урин “Израйлын нэгдсэн их цуглаан” хийж, зөвхөн Есүс Христ бол бидний Аврагч Эзэн мөн хэмээн тунхагласаныг дэлхийн 220-иод оронд шууд цацаж байлаа.

Үүний дараа Кристал Форум нь Гэр бүлийн хосуудын семинар, Залуучуудын цуглаан, Магтаал дууны их наадам гэх мэт эрч хүчтэй, ач холбогдолтой олон үйлчлэлүүдийг зохион байгуулж явуулсан. Ялангуяа сүмийн пасторууд нь И Жей руг Тэргүүн пасторын залбирч өгсөн эрх мэдэлт гар алчуурын (Үйлс 19:11-12) залбиралын хүчээр чин сэтгэлээсээ гэмшиж, сүм чуулганууд нь сэргэж, эдгэшгүй өвчин нь эдгэрцгээсэн юм. Тэд Оросын TBN, Родной TV, Ариун Бурхан TV, CNL, интернетээр өдөр бүр Тэргүүн пасторын сургаалуудыг сонсож улам бүр гүн баг итгэлтэй болж байлаа.



Энэ удаагын Магтаал дууны наадамд Израйлийн Ашдод, Хайфа, Назарет, Тель Авиваас ирсэн магтан дууны удирдагчид, Африкийн магтан дууны баг, Украйнаас ирсэн Оксамита, зэрэг Оросын Гирасим, Валели Коров олны танил болсон алдарт дуучид, “Шинэ Иерусалим” багийн удирдагч Александр Патлис, Беларусын нэрт магтан дууны баг гэх мэтийн олон орны хүмүүс болон магтан дууны удирдагчид төрөл бүрийн урлагийн тоглолт, үзүүлбэрүүдээр оролцлоо.

Манмин Төв Сүмийн Урлагийн Зөвлөлийн дэд удирдагч, Магтан Дууны удирдагч Хан Жү гёон номлогч нь Глори Вошип бүжгийн багтай хамт тус наадамд оролцож нээлтийн болон хаалтын үйл ажиллагаанд урлагийн тоглолтоо үзүүлж, үзэгчдээс нижигнэсэн алга ташилт, магтаалыг авч байлаа. Маш олон үзэгчид тэдний тоглолтыг өндөр сэтгэгдлээр

үзэж, магтан сайшааж, гайхан биширч байсан бөгөөд Манмин Сүмийн баг энэ наадмын хамгийн сайн байсан, магтан дууны удирдагч Хан Жү гёон номлогчыг Орос, Еврей хэлээр үнэхээр гайхамшигтай, маш цэвэрхэн дуулж байсан гэж ярьж байлаа. Зарим үзэгчид “Тэдний хувцас, гоёл чимэглэл нь үнэхээр гоё, Тэнгэрийн орныг үзэх шиг болсон” гэж онцгойлон гал халуун сэтгэлээр ярилцлага өгч байсан. Энэ наадмын үйл ажиллагааг тусгай хөтөлбөр болгон Оросын TBN-р дамжуулан гаргаж байв. Уг магтаалын наадмын зохион байгуулагчдын зүгээс өөрсдийн сэтгэгдлийг хуваалцахдаа “Галил нуурын эрэг дээр олон итгэлийн ахан дүүс нартайгаа хамт Эзэн Есүс Христийг магтан дуулах нь үнэхээр гайхамшигтай, сэтгэлийг минь хөдөлгөсөн үйл ажиллагаа болж өнгөрлөө. Энэ бүхэн И Жей руг Тэргүүн пасторын Израйльд хийсэн үйлчлэлийн үр жимс юм гэж хэлсэн юм.”

Хайр бол зохисгүй авирладаггүй

“Хайр бол зохисгүй авирладаггүй, өөрийнхийг эрддэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй” (1 Коринт 13:5).



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Зохисгүй авирлах гэдэг нь бүдүүлэг байх, хүндэтгэлгүй байх, зөв зохистой байдлыг эвдэх гэсэн утгатай юм. Цаг үе, хугацаанаас хамаараад мэндлэх, ярилцахад жаахан ялгаатай тал байж болох юм. Гэвч наад захын хүндлэх, эелдэг харицах харьцаа хүмүүсийн дунд байх хэрэгтэй. Хачирхалтай нь олон хүн бүдүүлэг авирладаг боловч тэд өөрсдийгөө бүдүүлэг авирлаад байна гэдгээ огт мэддэггүй. Ялангуяа, ойр дотны хүмүүс хоорондоо зохисгүй, бүдүүлэг харьцдаг байна. Та өөрийн дотны найзтайгаа энэ зэргийн жаахан зохисгүй, хамаагүй харьцаа байхад зүгээр, энгийн л үзэгдэл шүү дээ гэж хэлж магадгүй. Гэвч таны тэр хамаагүй, зохисгүй харьцаа, үг хэллэг тань түүнийг шархлуулж байдаг.

Хэрэв таньд жинхэнэ хайр байвал та зохисгүй авирлахгүй. Таньд маш их үнэтэй эрдэнэ байвал та нандиннан хадгалж, өөртөө ойрхон байлгадаг бизээ. Та магадгүй маш их нандингаж, хайрлаж, бүр нэг ширхэг зураас ч гаргахаас болгоомжлон хэрэглэх байх. Тэгвэл үүнтэй адил та найз нөхөддөө үнэхээр хайртай бол тэр чинээгээр хайрлаж хүндэтгэж чадна.

1. Бурханд бүдүүлэг, зохисгүй авирладаг хүмүүсийн байдал

Зарим хүмүүс Бурханд хайртай гэдэг боловч тэдний үйлдэл, үг яриа нь Бурханыг хайрлах хайраас хамаагүй хол байдагыг илчлэн харуулдаг. Хамгийн наад захын жишээ л гэхэд мөргөлийн үеэр зүүрмэглэх, унтах явдал юм. Та ерөнхийлөгчийн урилгаар зочиллоо гэж бодёе л доо. Гэтэл ярьж байх зуураа та унтаад, зүүрмэглээд байвал энэ нь үнэхээрийн их бүдүүлэг явдал болох юм. Үүний адил та Бурханд хүндэтгэлийн мөргөл үйлдэж байхдаа Түүний өмнө нойрмоглоод, унтаад байвал энэ нь таньд ямар ч тус нэмэр болохгүй бөгөөд харин ч та өөрөө Бурханд жинхэнээсээ хайртай эсэхэд эргэлзээтэй байна. Мөн хүндэтгэлийн мөргөлийн үеэр хоорондоо ярих, янз бүрийн хий хоосон

дэмий зүйлсийг бодох нь бас бүдүүлэг, зохисгүй явдал юм. Энэ нь Бурханд итгэх жинхэнэ итгэл, хүндэтгэл байхгүйг харуулж байна.

Мөн номлогч номлож байхад түүнтэй ярих, зүүрмэглэн унтах, дэмий зүйлс бодох нь бүдүүлэг юм. Иймэрхүү байдалтай байвал тэдний номлож буй сургаалаас та ивээл, ерөөлийг авч чадах эсэх нь эргэлзээтэй болно. Эцэст нь та эдгээр бүдүүлэг үйлдлийг мөргөлийн үеэр хийвэл энэ нь таньд өөрт чинь их хохирол учруулаад зогсохгүй мөргөлд оролцож байгаа бусад хүмүүст хүртэл хохиролтой байдаг.

Мөргөл дуусаагүй байхад эрг гарч явах нь бас бүдүүлэг, зохисгүй зан юм. Мөн хариуцсан үүрэг алба хүлээсэн хүмүүс мөргөлийг дуусгал оролцох хэрэгтэй бөгөөд мөргөлдөө бүх анхаарлаа төвлөрүүлэн, Төлөөлөгчдийн итгэлийн тунхагаас эхлэн Эзний заасан гуйлгаар дуусах хүртэл чин сэтгэлээсээ мөргөл үйлдэж, магтан дуулах, залбирах, өргөлийн цаг, зарлал сонсох гээд бүхий л цагийн турш чин сэтгэл зүрхнээсээ оролцох хэрэгтэй. Та яг үүнтэй адилхан зүрх сэтгэлээр Бурханд үйлчилж, мөргөлийн магтан дуу, эсийн бүлгийн үйлчлэл, сүмийн ажил үйлчлэл гэх мэт хариуцсан ажил үйлчлэлээрээ чин сэтгэлийн өргөл барих шаардлагатай.

Сүмд ирж чин сэтгэлээсээ мөргөл үйлдэх нь өргөл болдог бөгөөд энэхүү өргөлийг өргөхийн тулд та хамгийн түрүүнд хоцрохгүй байх ёстой. Ер нь хүмүүстэй уулзах уулзалтанд хоцроно гэдэг бүдүүлэг зохисгүй явдал хэдий ч тэр тусмаа Бурхантай уулзахдаа хоцроно гэдэг бүр ч байж болохгүй зохисгүй зүйл юм. Мөргөлд ирэхдээ урьдчилан залбирч, бэлтгэх нь хамгийн зохистой хүндэтгэл юм. Мөн мөргөл үйлдсэнийхээ дараа архи дарс ууж тамхи тагах, мөргөлийн үеэр юм идэх, бохь зажлах, утсаар ярих, хүүхдүүд чанга ярьж хашхирах, тоглох зэрэг үйлдлүүд нь Бурханы өмнө зохисгүй авирлаж, бүдүүлэг зан гаргаж байна гэсэн үг.

Мөн таны хэрхэн яаж биеэ авч яваа тань маш чухал. Хэрэв та сүмрүү явахдаа зохистой хувцас өмсөхгүй гэртээ өмсөж байсан хувцастайгаа явбал энэ нь зүй зохистой байдлыг эвдэж байна гэсэн үг. Та цэвэрхэн эмх цэгцтэй, зөв зохистой харагдах хэрэгтэй. Магадгүй та заримдаа ажлаасаа шууд яарч сандраад Лхагва гаригийн мөргөлд, эсвэл Баасан гаригийн мөргөлд ажлын хувцастайгаа очиж болох юм. Энэ тохиолдолд Бурхан таныг Түүний өмнө зохисгүй бүдүүлэг байна гэж хэлэхгүй. Учир нь завгүй ч гэсэн мөргөлд оролцохыг хүсч байгаа таны зүрх сэтгэл Түүнд илүү их тааламжтай байх болно.

Хэрэв та ямар нэгэн яаралтай хэрэг гараад хэн нэгний залбирлыг мөрөн дээр нь цохин

байж таслаад, нөгөө хүн ч бас залбирлаа таслаад таньтай ярих нь хоёулаа зохисгүй авирлаж байгаа хэрэг. Яагаад гэвэл та хоёр Бурхантай ярьж байсан яриагаа шууд таслаад өөр тийшээ ярьж байна гэсэн үг.

Бид чин сэтгэлээсээ Бурханд талархан магтан дуулж, мөргөл өргөж, залбирахад Тэр бидний чин сэтгэлийг баяртайгаар хүлээн авч ивээл ерөөлийг бидэнд шагнал болгон буцаан өгдөг. Харин яг эсрэгээр бид дахин дахин бүдүүлэг зан гаргаж, зохисгүй авирлах үед Бурханы өмнө гэмийн хана босгож өвчин зовлон, осол аваар гэх мэтийн янз бүрийн хүнд хэцүү асуудалтай тулгардаг. Энэ үед хичнээн их залбирсан ч хариулт авч чаддаггүй юм.

2. Сүмд бүдүүлэг, зохисгүй авир гаргадаг хүмүүсийн байдал

Ариун байх гэдэг нь зөвхөн өөрөө л гэм нүглээ хаяж, ариусаж, цэвэр цэмцгэр болохыг хэлэхгүй. Үүнд сүмийн дотор болон гадна байгаа бүх газар, тоног төхөөрөмж, эд анги бүгд хамаарна. Тиймээс бид сүмийн бүх газар хэлж, ярьж байгаа шигээ онцгойлон анхаарал тавьж, хийж гүйцэтгэх хэрэгтэй. Мөн ертөнцийн ажил хэрэг, зугаа цэнгэлийн тухай ярилцах, зодолдох, сүмийн ариун эд зүйлсийг эвдэх, өргөлийн дугтуйг хувийн зорилгоор ашиглах ёсгүй юм.

Сүмд худалдаа наймаа хийхийг хатуу хориглодог. Зарим хүн сүмд цахимаар төлбөр тооцоогоо хийдэг ч үүнийгээ худалдаа наймаа хийлээ гэж боддоггүй, мэддэг ч үгүй байна. Гэтэл энэ нь яахийн аргагүй нэг нь зарж нөгөө нь худалдан авч байгаа үйлдэл мөн юм. Матай 21:12-13г Есүс сүмд мөнгө солигчдын ширээг, өргөлд зориулан мал, амьтан зарж байсан хүмүүсийн сандлыг хөмөрч байсаныг бодох хэрэгтэй. Хэдийгээр тахилд хэрэглэгдэх мал амьтан байсан ч сүм дотор худалдаа наймаа хийхийг Тэр зөвшөөрөөгүй. Тиймээс сүм бол зах биш, хэн нэгэн хувийн ашиг сонирхолоо даган худалдаа наймаа хийх нь хэзээ ч байж болшгүй хэрэг.

Сүм бол онцгойлон Бурханд мөргөлөөр ариун өргөл өргөх, Түүнтэй уулзаж харилцаа тогтоох газар юм. Тиймээс бид ариун нандин сүм гэдгийг мартаж болохгүй бөгөөд Бурханы өмнө зохисгүй, бүдүүлэг авирлах ёсгүй.

3. Бусад зохисгүй, бүдүүлэг ханддаг хүмүүсийн байдал

Магадгүй та өөрийн эрх ашгийн төлөө бусдын нөхцөл байдлыг бодолцохгүйгээр зохисгүй, бүдүүлэг авирладаг байж болох юм. Бид хэдий сул дорой, өөрөөс нь доогуур байр суурьтай хүн байсан ч тэднийг хүндэтгэн, эелдэг хандах хэрэгтэй. Тэдэнд хүндрэл учруулахгүйн тулд шөнө оройн цагаар утасдах, завгүй байхад нь олон зүйл

ярих хэрэггүй. Ямар нэгэн хурал цуглаанаас хоцрох, бусдын өмнө гэнэт гарч ирэх нь зохисгүй бүдүүлэг авир юм.

Хүмүүс хоорондоо хамаагүй, эвгүй үгээр ярилцаж байхыг хараад их дотно харьцаатай хүмүүс байна гэж боддог. Мэдээж зарим хүмүүсийн хувьд хэн нэгнийхээ алдаа дутагдал, өө сэвийг хараад байхааргүй тийм дотно харьцаатай байж болох юм. Гэхдээ хэн ч бусдын сэтгэлийг 100% мэддэггүй шүү дээ. Жишээ нь нэг хүн найзтайгаа үргэлж маш дотно харьцаатай гэж боддог байтал харин нөгөө найз нь яг түүнтэй адилхан тийм дотно харьцаатай гэж боддоггүй байж болно. Тиймээс бид үргэлж өөрсдийгөө бусдын оронд тавьж үзэхийг хичээх хэрэгтэй юм.

Олон хүн хамгийн дотны найз нарынхаа санаандгүй хэлсэн үгнээс шархалсан байдаг. Хэрэв та гэр бүл, дотны найз нөхөд, ах дүү наргаа зохисгүй, бүдүүлэг ааш гаргавал таны байдал бүр улам дордож, бусад хүмүүстэй харьцаагаасаа ч илүү муу харьцаатай болж болох юм. Мөн зарим хүн өөрөөсөө залуу, эсвэл доогуур албан тушаалын хүнтэй их зохисгүй харьцдаг. Тэд их дээрэнгүй, үл тоож эвгүй сэтгэдэл төрүүлж, захирч тушаасан байдлаар ярьдаг.

Эцэг эх, багш нарыгаа дээдлэн, асарч халамжлах нь мэдээжийн хэрэг ч өнөөдөр чин сэтгэлээсээ хайрлаж, тэднийхээ төлөө зүтгэн яваа хүнийг олоход хэцүү болжээ. Зарим хүмүүс цаг хугацаа өнгөрч удам угсаа өөрчлөгдсөнөөс болж сайн туслаж чадахгүй байна гэдэг. Харин цаг хугацаа өнгөрсөн ч хэзээ ч өөрчлөгдөж болохгүй гэж зүйл байдаг. Левит 19:32-г уншвал “Буурлын өмнө босон зогсож, настан дээдлэн, өөрийн Бурханыг хүндэл. Би бол Эзэн” гэсэн байна. Бурхан биднийг хүнийхээ хувьд үүргээ биелүүлээсэй гэж хүсдэг учраас ертөнцийн дэг журам, бүр хуулийн дагуу ч бай бид бусад бүдүүлэг дээрэнгүй байх хэрэггүй юм.

Хайрт итгэл нэгт ахан дүүс минь, олон хүн ихэнхи цагаа бусадтай уулзаж, ярилцаж, ажиллаж, хамт хооллон өнгөрөөдөг боловч хүн бүр боловсрол, мэдлэг, төрсөн нутаг, соёл иргэншил, дуртай зүйлээрээ өөр өөр байдаг. Тэгвэл эелдэг зан, боловсон байдлын түвшин ямар байх хэрэгтэй вэ? Энэ л бидний зүрх сэтгэл доторх хайрын хууль юм.

Хайрын хууль гэдэг нь Өөрөө хайр болсон Бурханы хууль юм. Бид Бурханы үгийг зүрх сэтгэлдээ хир гүн суулгаж, түүнийг амьдралдаа хэрэгжүүлж, Эзний тушаалын дагуу амьдарч чадна тэр чинээгээр хэнд ч бүдүүлэг, зохисгүй зан авир гаргахгүй байж чадна. Хайрын хуулийн бас нэг чухал зүйл бол “хүндлэл, анхаарал халамж” юм. Бусдыг хүндэлж, анхаарал халамж тавих нь агуу хүчийг бий болгож чаддаг. Эзэнд үйлчлэх сэтгэлээр бүх хүнд хайраар үйлчлэх болтугай хэмээн би Их Эзний нэрээр хүсэн ерөөе!

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773
www.manmin.org
www.manmintv.org

Би хир зэрэг сайхан сэтгэлийг сэтгэлдээ бий болгосон бэ?

Харанхуй өчүүхэн ч байхгүй гэрлийн уг үндэс болох Бурхан Өөрийн хүүхдүүдээ ч мөн төгс гэрэл дотор байхыг хүсдэг билээ. Гэм нүгэлээ хаяж, сайныг үйлдэхийн хирээр харанхуйг зайлуулах сүнслэг эрх мэдлийг авч Бурханаас ирэх хайр, ерөөлүүдийг ч авдаг.

Дараах 3н асуултуудыг тунгаан бодсоноор би хир их сайхан сэтгэлийг өөртөө бий болгож, гэрэл дотор хир зэрэг явж байна вэ гэдгээ шалгаж үзэх боломжтой юм.

Асуулт

“Би өгч, авч сурсан уу?”

Үйлс 20:35-г уншвал “... Мөн Эзэн Есүсийн айлдсан ‘Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй’ гэсэн үгийг санагтун гэж хэлэв.” Эндээс ‘Өгөх’ ‘авах’ гэдэг нь мөнгөнөөс гадна чин сэтгэл, хичээл зүтгэл, цаг зарцуулалт зэрэг хэрэгтэй үед нь туслах бүхий л үнэний үйлсийг хэлж байгаа юм.

Гэтэл зарим хүмүүс тусламж авлаа гэхэд тэр ивээлийг мөн ачийг нь хариулах гэж хичээнгүйлэн итгэлийн амьдарлаар амьдрах төдийгүй өөрөө ч мөн бусдад тусалж хувиршгүйгээр талархлаа илэрхийлэн үйлддэг. Харин эсрэгээр нь зарим хүмүүс талархалаа илэрхийлсэн ч өөрийн эрх ашгаас болоод сайн үйлсийг хийдэггүй. Бусдад туслах нь сайхан сэтгэлээс гардаг үйлс гэдгийг мэддэг ч тэд өөрсдөө хийхийг хүсдэг ч хийдэггүй. Мөн зарим хүмүүс нь авсан ерөөл, ач тусыг хариулах гэж итгэмжтэй зүтгэдэг байгаад, хувирдаг хүн, түүнчлэн хэн нэгэнтэй муудалцах, зөрчилдөх явдал гарвал ачийг хариулна гэж чин сэтгэлээсээ бодож байсанаа ч мартаж орхидог хүмүүс байдаг.

Нөгөө талаар зарим хүн нь нэгэн баг, бүлэг уулзаж хуралдахаар боллоо гэхэд хурал цуглааныг амжилттай сайн явуулахын тулд бусдаас эрт ирж бэлтгэл ажлыг дахин хийж, шалгадаг байсан ч энэ удаад эрт ирж, бэлтгэл хийгээгүйдээ санаа нь зовж дараагийн удаа

Христэд итгэдэг олон хүн Бурханаас сайхан сэтгэлтэй болж бусдад үйлчилж, тэдний төлөө золиослох зүрх сэтгэлтэй болохыг хүсэн гуйдаг ч яг бодит амьдрал дээр өөрт нь ашиггүй л бол өрөөлийг ойлгож, хүлээн зөвшөөрч чаддаггүй байна.

Жишээ нь нэгэн сүмийн ажилчин тантай хамт ажиллаж байгаад ид ажлын үер гэрлүүгээ явлаа гэж бодъё. Энэ үед та түүнийг сайхан сэтгэлээр бодвол түүнд явах ямар нэгэн учир шалтгаан байсан болоод л явлаа даа гэж бодоод та уурлаж дургүйцэхгүй харин ажлаа чин сэтгэлээсээ илүү сайн хийж дуусгах болно.

Гэвч зарим хүмүүс “би ч бас завгүй, хийх ажил их байгаа. Хийх ёстой чухал ажил нь энэ биш үү? Тэр заавал явах шаардлагатай юм уу?” гэж боддог. Нөгөөтэйгүүр хувиа бодсон, амиа хичээсэн гэж шүүн дүгнэж ч болох юм. Эсвэл түүнийг дараа нь өөр нэг сайн дураараа хийх ажил гарах үед миний оронд нөхөж ажиллаад өгөөрэй гэж гуйна даа хэмээн бодож ч болох юм. Тэгвэл энэ нь Бурханы өмнө сайхан сэтгэл байж чадахгүй. Харин ч тэдний зүрхэнд сайхан сэтгэл байхгүй, зүгээр л мэдлэгийг хуримтлуулсан учраас сайн зүйл

Зарим хүмүүс өөрийн дээд албан тушаалын хүмүүсийн үгэнд дуулгавартай байж сэтгэлээсээ ажилладаггүй, дуулгаваргүй байдаг. Хийх ёстой зүйлээ хийхгүй байхад нь шахаж шаардвал дургүйцэж “дандаа тушааж, захирч байх юм” гэж эгдүүцэн хэлдэг. Ийм хүмүүс дэндүү бардам, тэдний сэтгэлд таарч тохирч нийцэхгүй л байвал бусадтай эв нэгдэл хагалж, дургүйцэн хийх ёстой зүйлээ ч хийдэггүй байна.

Жишээ нь танай ажил дээр нэг төсөл явагдаж байна гэж бодъё. Нэгэн доод тушаалын хүн танд хэлэхгүйгээр танай даргад тайлангаа өгчихжээ. Энэ тохиолдолд та магадгүй ихэд тавгүйцэж “Яагаад тэр надад хэлсэнгүй вэ? Яагаад тэр миний саналыг ч асуусангүй вэ?” гэж бодож болох юм. Харин өөрсдийнх нь тушаалыг дагаагүй тохиолдолд хүмүүс ихэвчлэн ингэж л боддог. Өөрт нь таалагдахгүй, санал нийлэхгүй зүйлийг хий гэж үүрэг болговол хүмүүс гомдоллон, цухалдаж, янз бүрийн бодол бодож хямардаг.

Байгууллага бүр, баг болгон дотоод дүрэм журамтай, хүн бүр өөрийн гэсэн үүрэг даалгавартай ч өөр өөр нөхцөл

заавал цагаасаа эрт ирэхийг хичээдэг хүмүүс байхад хурлаас хоцордог зуршилтай хүмүүс бас байдаг. Түүнчлэн хэдийгээр тэд цагтаа ирсэн ч бүх юм бэлэн болсоны дараа л ирдэг хүмүүс ч бас байдаг бөгөөд тэд бусдаар үйлчлүүлэх зуршилтай болчихсон байдаг байна.

Үүнээс гадна зарим нь бусдад тусалж, бэлэг өгч, заавал хийх шаардлагагүй зүйлийг ч хайн хийдэг бусдад үйлчлэх дуртай хүн ч бий. Гэсэн ч хэн нэгнээс ямар ч талархал хүлээн авахгүй байх юм уу хүлээн зөвшөөрөгдөж чадаагүй, найдаж байсан зүйлээ олж чадаагүй тохиолдолд тэд “тэр хүн хүний тусыг мэддэггүй, бардам, бүдүүлэг” гэж бодож гомддог. Ингэж өөрийнхөө хийсэн бусдаар үнэлүүлэхийг хүсвэл Бурхан үүнийг “сайн” үйлс гэж тооцдоггүй байна.

Бурханаар хүлээн зөвшөөрөгдсөн сайхан сэтгэл, сүнслэг сэтгэл бол бусдад амар тайван баяр баясгаланг, тэдний хүсэж байгаа зүйлийг шууд, их амархан өгч чаддаг юм. Бурхан бидэнд нэг удаа өгөөд больчихдоггүй үргэлжлүүлэн хамгийн сайныг өгөөд л байхыг хүсдэг. Бид “түүнд тусласан одоо хангалттай” гэж бодолгүйгээр Бурханы адил авахаасаа өгөхдөө баяртай байх ёстой юм.

болохгүй.

Хэрэв та өөртөө биш бусдад сайхан сэтгэлийн талаар шаардлага тавиад байвал бүх зүйл миний зөв, би сайн байсан гэж буруугаар бодоход хүрдэг. Та үнэхээр их завгүй ид ажлын үер Бурханы хаанчлалын төлөө жаахан ч болов цаг зав гарган ажиллаж байгаа учраас сүнслэг сайхан сэтгэлтэй болж байгаа гэж бодож байж ч болох юм. Харин ид ажлын үер та ийм эрт явах гэж байгаа юм уу? гэж хэн нэгэн нь асуухад л таны зүрх сэтгэл шархалж “Тэр надад ингэж хэлэх хэрэгтэй байсан юм уу? Би эрт явж байгаадаа өөрөө ч хүртэл харамсаж байсан. Жаахан хугацаанд ч гэсэн би маш их зүйлийг хийж шаргуу ажилласанд харин надад баярлах хэрэгтэй биш үү” гэж та гомдож, өөрийн тань зөв байсан гэж бодоход хүрнэ.

Бид өөрсдийн үзэл бодол, ашиг сонирхолоо бодох л юм бол сүнслэг сайхан сэтгэлийг олж авч чадахгүй. Хүний сайхан сэтгэл бол дандаа бусдын байр сууринаас харж боддог. Бид энэ аргыг сонговол сүнслэг сайхан сэтгэлийг олж авахад маш хэцүү байх болно. Харин Бурханы алдрын төлөө, бусдын сайн сайханы төлөө хийвэл маш амархан олж авах болно.

байдалд хоорондоо харилцан ойлголцох шаардлагатай байдаг. Гэвч тухайн нөхцөл байдлаас шалтгаалан ажилчдаа ойлгож өгч, дэмжих үе байдаг бол дэг журмын дагуу үйлдүүлэхийн тулд барих үе ч бий. Доор ажилдаг хүн нь дэг журмыг зөрчих үед удирдаж буй дээд хүн ямар ч байсан түүнийг ойлгож өгөх, дэмжих нь сүнслэг сайхан сэтгэл биш юм гэдгийг ойлгож хэрэгтэй юм.

Тэгвэл бид цаг үргэлж үнэн дотор энэ мэт нөхцөл байдлуудыг ялгаж танихын тулд бид юу хийх шаардлагатай вэ? Бурханд таалагдахын тулд алийг нь сонгох хэрэгтэй вэ? Бид бусдыг захирах, толгой болох, үйлчлүүлэх, өөрийгөө дөвийлгөх хүслээ хаях шаардлагатай. Тэр үед л биднээс ойлгохыг шаардаад байгаа учир шалтгааныг ялгаж салгаж чадах бөгөөд дутагдаж гачигдаж байгаа хүмүүст туслах, сургах, дасгалжуулахад бидний оролцоо хэрэгтэй байдаг. Түүнчлэн бид ямар үед даргын үүрэг даалгаварыг дуулгавартай дагах, ажилчдын санал бодлыг хүлээж авах, даргадаа санал болгох зэргийг маш ухаалгаар мэдэрч хэрэгжүүлж чаддаг болно.

Асуулт

“Би захирах захирагдах ёсонд зохицож хир зэрэг дуулгавартай ажилдаг вэ?”



Рита Хазин,
Марк Хазин болон тэдний хүүгийн гэр бүл

“Израйлийг хайрладаг сүнслэг удирдагчтай уулзсандаа би баяртай байна”

**Рита Хазин итгэгч
(Израйлийн Ашдод Манмин Сүм)**

Би Украинд төрсөн Еврей хүн билээ. Гэвч Бурханыг сайн мэдэхгүй өөрийн бүх амьдралаа үзэн ядаж, жигшин зэвүүцдэг байлаа. Харин хүүгээрээ дамжуулан Бурхан болон Эзэнийг мэдсэн юм. Нэгэн өдөр хүү маань Бурханы амласан газар Израйльд очиж ажиллахыг хүсэж байгаагаа хэллээ.

Үүнийг сонсоод нөхөр бид хоёр их цочирдож, таньж мэдэхгүй газар, хэл мэдэхгүй хүмүүсийн дунд очих гэж байгаа болохоор хүүгийнхээ төлөө маш их санаа зовж байсан ч зогсоох ямар ч арга байгаагүй.

Ингээд 1991 онд хүү маань Израйль руу явсан. Урам хугарсан, гансарч гиюүрсэн амьдрал дунд амьдарч байхад хүүгийн минь “Ээж ээ, итгэлгүй байгаа учраас айдас түгшүүр ирж байгаа юм. Та яагаад Библи уншдаггүй юм бэ?” гэсэн үг нь гэнэт толгойд аянга мэт орж ирэхэд амьдралдаа анх удаа өвдөг дээрээ сөхрөөд “Эзэн минь! Би Тантай уулзмаар байна, Таныг мэдмээр байна. Надад итгэл өгөөч. Би хүүгээ Танд даатгаж байна” гэж залбирсан.

Тэр цагаас хойш Библи уншиж, үнэхээр гайхалтайгаар олон зүйлийг ойлгож, ухаарч байлаа. Бурхан над шиг Еврей хүнийг сонгож, хүн төрөлхтөнийг аврахын тулд цорын хүү Есүсээ дэлхий рүү илгээснийг мэдсэн. Бурханы уг надад амийн талх болон намайг амьдруулж, надад жинхэнэ амар тайваныг өгсөн юм.

1991 оны 9-р сард Зөвлөлт

Холбоот Улс нурсаны дараа маш олон улс орон Олон Улсын Холбоонд үүд хаалгаа нээж хүмүүс нэг орноос нөгөө рүү цагаачлан гарах болсон. Украинд гэмт хэрэг өсөж, амьдрахад их хүнд болж байлаа. 1997 онд хүүгийнхээ амьдарч байсан Израйль руу нүүж, 1998 онд Ашдод-д манай гэр бүл гэртээ сүм нээсэн ч Израйльд амьдрахад маш хүнд байсан билээ. Олег Хазин пастор миний хүү амьдрахын тулд ажил хийх шаардлагатай болохоор үйлчлэлдээ бүрэн анхаарал тавьж чаддаггүй байлаа. Энэ байдалд нь би их харамсдаг байв. Бид сүнслэг удирдагчтай уулзаж Бурханы хүслийг дагуу олон хүний сүнсийг аврахад өөрсдийгөө зориулахсан гэсэн чин хүсэлтэй байсан.

Энэ үед 2007 онд Доктор И Жей руг Тэргүүн пастор Израйльд ирж сайн мэдээ тараахад нь уулзсан юм. Түүний залбирлаар үй олон хүн эдгэрч, эрх мэдэлт хүчээр гайхамшгууд бий болж, жинхэнэ амьд сургаал сонсогдож байсаныг бид гэрчилж чадна. Энэ бүгдийг хараад бидний хайж байсан жинхэнэ сүнслэг удирдагч мөн байна гэж ухаарсан. Тэр Израйлийн пасторуудад урам зориг оруулж, хайрлаж, залбирч, санхүүгээр туслаж дэмжиж байв. Түүний дэмжлэгээр Израйлийн Пасторуудын холбоо Кристал Форум нэрээр 2008 онд байгуулагдсан юм.

2009 оны 9-р сард И Жей руг Тэргүүн пасторын Иерусалимд болсон Израйлийн Нэгдсэн Их Цуглаанд бид мөн л оролцсон. Израйлийн нийслэл Иерусалим хотод тэр эр зоригтойгоор Есүс бол бидний аврагч Эзэн мөн гэж тунхаглаж Бурханы агуу гайхалтай

эрх мэдэлт хүчийг харуулж чадсан билээ. Тоо томшгүй олон хүн хорт хавдар, үе мөчний өвчин, чихрийн шижин өвчнөөс эдгэрч байсан. Эдгэрсэн хүмүүс харааны шил, тэргэнцэрээ хаяцгааж байсан. Тэр цуглаан дээр маш олон гайхамшгууд бий болж Бурханд алдрыг өргөж байлаа. Мартахын аргагүй агуу гайхамшигийг харуулж, мэдрүүлсэн цаг үе байсан.

Тэр үеэс хойш Израйльд христийн сайн мэдээнд эргэлт гарч, сэргэсэн юм. Пасторууд эрч хүчтэйгээр үйлчлэлээ хийж, Израйльд цөөнх гэж гадуурхагдаж байсан христчин Еврей хүмүүс хайр халамж авч, гадаа задгай талбайд аз жаргалтайгаар Бурханыг магтан дуулж, Бурханы өгсөн гайхамшигтай итгэлгээр баяр хөөртэй амьдрах болсон.

Би хэдий 67 нас хүрсэн эмэгтэй боловч Бурханы үгээр зэвсэглэж хүмүүсийг аврахын төлөө Манмин Олон Улсын Семинарт (MIS) суралцаж байгаа билээ. Тэргүүн Пасторын *Загалмайн Утга Учир, Там I; II, Итгэлийн Хэмжээ* гэсэн номнуудыг ширээнийхээ ном болгон эсийн бүлэгтээ үг хуваалцаж номлодог болсон. Өөрийн өөрчлөлтийн төлөө чин сэтгэлээсээ гэмшин залбирахад эдгээр номуудаар дамжуулан үнэн дээр бат зогсоход Ариун Сүнс надад тусладаг.

Зөвхөн Есүс Хрис бол цорын ганц Аврагч Эзэн гэдгийг надад ухааруулж өгсөн Бурхандаа бүх алдар магтаал, талархал, хүндэтгэлийг өргөө. Эрхэм нандин үнэт сургаалаараа Израйлийг байлдан дагуулсан Тэргүүн Пастортаа чин сэтгэлийнхээ угаас талархаж байна.

“Дунд чихний идээт үрэвсэлээс эдгэрсэн минь”



**Жу Кёон а туслагч
(Сүнчеон Манмин Сүм)**

2011оны 10-р сард миний зүүн чих найтаахад маш их өвдсөн юм. Тэгээд эмнэлэгт очиж шинжилгээ өгөхөд эмч “дунд чихний идээд үрэвсэлтэй болсон байна. Энэ өвчин хүндрэх юм бол тархинд нөлөөлж үхэлд хүргэх аюултай тул долоо хоногийн дотор дээд шатны эмнэлэгт үзүүлж хагалгаа хийлгэх шаардлагатай” гэж хэлээд эмчилгээ бичиж өгсөн.

Яг тэр үед эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн багийн удирдагч, мөн Манмин салбар сүмүүдийн удирдагч И Хи сон пастор Сүнчеон Манмин Сүмийн нэг жилийн ойн мөргөлд анх удаа ирсэн юм. Би түүнээс гар алчуурын (Үйлс 19:11-12) залбирал авахад их хүчтэй хурц өвдөж байсан өвчин байхгүй болсон. Гэвч чих маань шуугиж, сайн сонсож чадахгүй л байлаа.

Үүний дараа Даниел залбиралд орой бүр очиж эдгэрч, өөрчлөгдөхийн төлөө залбирч байлаа. Залбирч байхад Бурхан надад нөхөр маань итгэлийн амьдралаар сайн амьдарч чадахгүй байгаа ойлгуулж өгсөн. Бурхан миний өөрийн зөрүүд зан, өөрийн бодол санаа, бусдаар үйлчлүүлэх хүсэл миний дотор байгааг харуулж өгсөн. Би гэмшин залбирч, бусдыг ойлгож, даруу зүрх сэтгэлээр үйлчлэхийг хичээж байлаа.

Түүний дараахан би Сөүлд ирж Тэргүүн пастораас залбирал аваад 2013 оны 5-р сарын 4-ний өдөр би бүрэн эдгэрсэн нь батлагдсан юм. Энэ өвчин аяндаа зүгээр болдог өвчин биш, хагалгаанд орсон ч хор уршиг ихтэй, дахин өвчлөх аюултай байсан юм. Энэ хүнд өвчнөөс минь эдгээж өгсөн Бурхан Аавада бүх алдар, магтаал, талархалыг өргөж байна.



Доктор И Жей руг пасторыг урьсан Израйлийн Нэгдсэн их цуглаан.

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

залбирал цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойши мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган

Чуулганы утас: 976-11-351437

Чуулганы хариуцсан төлөөлөгч:
Г. Анхбаяр СМТ 976-91173712
976-91615337

Е- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин